



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид

Утас: 99812811

Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 70-16-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

АСГАТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.УЯНГА-Д

2025.02.11 № 81
танил _____ -ийн № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд Улсын төсвөөс 456,529.2 мянган төгрөгийн, Орон нутгийн төсвөөс 23,416.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 34,954.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 18,480.8 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд 61 нэр төрлийн 8,943.3 төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй, цэцэрлэгийн хүүхдийн хоолыг нормативт зардлаас 552.4 мянган төгрөгөөр дутуу олгосон, гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагддаг ТҮБД-ээр цалинждаг эрхлэгч, багш, туслах багшид эрхлэгчийн тушаалаар үр дүнгийн мөнгөн урамшуулал 6,782.9 мянган төгрөгийг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 13,189.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 19,900.0 мянган төгрөгийн хайс нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн

D:\tik\Албан бичиг\Дүгнэлт-2025

81757909

Хурлын даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/58 захирамжаар 17 нэр төрлийн 6,185.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны 13 дугаар тогтоолоор 3,030.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

 Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31
/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,654,635.54	56,700,342.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,980,234.64	34,954,496.48
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,980,234.64	34,954,496.48
3121	Төгрөг	9,980,234.64	34,954,496.48
31211	Төрийн сангийн харилцах	9,980,234.64	34,954,496.48
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		4,400.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		4,400.00
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	18,674,400.90	21,741,446.00
351	Түүхий эд материал	2,804,788.40	1,702,400.00
3511	Тусгай зориулалттай материал	2,804,788.40	1,702,400.00
354	Хангамжийн материал	15,869,612.50	20,039,046.00
3541	Бичиг хэргийн материал	11,000.00	344,150.00
3542	Аж ахуйн материал	11,752,306.00	17,435,956.00
3544	Түлш, шатах тослох материал	556,000.00	925,000.00
3545	Барилгын засварын материал	125,000.00	125,000.00
3546	Хүнсний материал	3,425,306.50	1,208,940.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	132,067,186.78	147,954,962.54
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	132,067,186.78	147,954,962.54
392	Биет хөрөнгө	127,007,186.78	143,224,962.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,778,900.00	89,778,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7,788,125.16	-9,284,440.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,148,982.00	50,475,054.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,086,085.44	-26,307,096.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,615,996.00	23,585,978.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,818,970.66	-8,171,122.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,544,000.00	24,444,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-908,799.96	-1,817,599.92
39217	Ном	521,290.00	521,290.00
393	Биет бус хөрөнгө	5,060,000.00	4,730,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-990,000.00	-1,320,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,400,000.00	4,400,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	160,721,822.32	204,655,305.02
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,925,683.99	18,480,813.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,925,683.99	18,480,813.39
413	Өглөг	4,925,683.99	18,480,813.39
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	3,450,506.91	12,999,744.48
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,475,177.08	5,481,068.91
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	155,796,138.33	186,174,491.63
51	Засгийн газрын хувь оролцоо	155,796,138.33	186,174,491.63

	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон		
511	нутгийн сан	48,148,231.80	48,148,231.80
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	27,035,432.53	57,413,785.83
5121	Өмнөх үеийн үр дүн	27,035,432.53	27,035,432.53
5122	Тайлант үеийн үр дүн		30,378,353.30
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,612,474.00	80,612,474.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	160,721,822.32	204,655,305.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	346,877,736.00	513,034,410.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,629,036.00	33,089,110.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,629,036.00	33,089,110.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,679,830.00	28,411,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,949,206.00	4,677,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,248,700.00	479,945,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	305,488,900.00	456,529,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	305,488,900.00	456,529,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,759,800.00	23,416,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,759,800.00	23,416,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	340,722,812.71	482,656,056.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,722,812.71	482,656,056.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	340,722,312.71	482,656,056.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,022,458.31	356,917,190.62
210101	Үндсэн цалин	157,915,417.96	213,433,690.62
210102	Нэмэгдэл	67,689,403.35	136,110,700.00
210104	Урамшуулал	14,417,637.00	7,372,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,815,651.96	44,824,485.11
210201	Тэтгэврийн даатгал	20,158,251.96	30,547,794.44
210202	Тэтгэмжийн даатгал	2,414,200.00	3,569,171.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,600.00	1,784,585.93
210204	Ажилгүйдлийн даатгал	483,000.00	1,784,585.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,828,600.00	7,138,346.91

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,678,977.08	23,342,619.99
210301	Гэрэл, цахилгаан	1,135,574.08	1,421,491.19
210302	Түлш, халаалт	18,043,403.00	21,408,828.80
210303	Цэвэр, бохир үс	500,000.00	512,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,182,926.00	4,108,260.24
210401	Бичиг хэрэг	983,500.00	142,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,768,726.00	828,471.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,430,700.00	333,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		2,804,788.40
2105	Нормативт зардал	28,447,431.00	30,868,166.50
210502	Хоол, хүнс	28,447,431.00	30,868,166.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	874,500.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	874,500.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		1,700,000.00
210702	Дотоод албан томилолт		1,700,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		
2108	хүраамж	541,500.00	1,777,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		756,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	541,500.00	1,021,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,158,868.36	18,117,734.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,439,700.00	2,884,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,262,500.00	2,709,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,456,668.36	12,523,584.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500	
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500	
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,154,923.29	30,378,353.30
	145 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
	225 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,154,923.29	30,378,353.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	325,248,700.00	479,945,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,248,700.00	479,945,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	305,488,900.00	456,529,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	305,488,900.00	456,529,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,759,800.00	23,416,100.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн		
132001	төсөвт байгууллага/	19,759,800.00	23,416,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	324,498,683.36	454,971,038.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,498,683.36	454,971,038.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,498,183.36	454,971,038.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,209,503.36	347,248,876.86
210101	Үндсэн цалин	151,437,602.01	203,765,376.86
210102	Нэмэгдэл	70,374,264.35	136,110,700.00
210104	Урамшуулал	14,397,637.00	7,372,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,178,100.00	44,947,961.30
210201	Тэтгэврийн даатгал	20,520,700.00	30,671,270.63
210202	Тэтгэмжийн даатгал	2,414,200.00	3,569,171.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,600.00	1,784,585.93
210204	Ажилгүйдлийн даатгал	483,000.00	1,784,585.93
210205	Эрүүл мэндийн даатгал	4,828,600.00	7,138,346.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,759,830.00	22,416,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,135,574.08	1,421,491.19
210302	Түлш, халаалт	17,124,255.92	20,482,308.81
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	512,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	27,721,800.00	28,651,800.00
210502	Хоол, хүнс	27,721,800.00	28,651,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	999,500.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	999,500.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	541,500.00	1,021,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	541,500.00	1,021,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,087,950.00	9,684,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,463,450.00	6,760,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,624,500.00	2,924,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500	
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	500	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	500	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	750,016.64	24,974,261.84
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	Дотоод эх үүсвэрээр ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	750,016.64	24,974,261.84
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,980,234.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		34,954,496.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
120...	оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	20,880,509.24	
7	Тайлант үеийн үр дүн			6,154,923.29	155,796,138.33
1020...	оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	27,035,432.53	155,796,138.33
17	Тайлант үеийн үр дүн			30,378,353.30	30,378,353.30
1920...	оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,148,231.80	80,612,474.00	57,413,785.83	186,174,491.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,925,500.00	431,554,938.16	58,370,561.84	88.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,925,500.00	431,554,938.16	58,370,561.84	88.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,925,500.00	431,554,938.16	58,370,561.84	88.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,865,900.00	347,248,876.86	32,617,023.14	91.41
210101	Үндсэн цалин	236,062,200.00	203,765,376.86	32,296,823.14	86.32
210102	Нэмэгдэл	136,430,900.00	136,110,700.00	320,200.00	99.77
210104	Урамшуулал	7,372,800.00	7,372,800.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,355,100.00	44,947,961.30	407,138.70	99.1
210201	Тэтгэврийн даатгал	30,842,000.00	30,671,270.63	170,729.37	99.45
210202	Тэтгэмжийн даатгал	3,627,900.00	3,569,171.90	58,728.10	98.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,814,200.00	1,784,585.93	29,614.07	98.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,814,200.00	1,784,585.93	29,614.07	98.37
210205	Эрүүл мэндийн даатгал	7,256,800.00	7,138,346.91	118,453.09	98.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,416,100.00		22,416,100.00	
210301	Гэрэл, цахилгаан	1,570,000.00		1,570,000.00	
210302	Түлш, халаалт	20,346,100.00		20,346,100.00	
210303	Цэвэр, бохир үс	500,000.00		500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	29,555,400.00	28,651,800.00	903,600.00	96.94

210502	Хоол, хүнс	29,555,400.00	28,651,800.00	903,600.00	96.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00		1,000,000.00	
210604	Урсгал засвар	1,000,000.00		1,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хүраамж	1,021,600.00	1,021,600.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,021,600.00	1,021,600.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,711,400.00	9,684,700.00	1,026,700.00	90.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,786,900.00	6,760,200.00	1,026,700.00	86.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,924,500.00	2,924,500.00		100
1 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		489,925,500.00	456,529,200.00	33,396,300.00	93.18
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		456,529,200.00	-456,529,200.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих		456,529,200.00	-456,529,200.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,416,100.00		23,416,100.00	
132001	Орон нутгийн төсвөөс	23,416,100.00		23,416,100.00	
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС	466,509,400.00		466,509,400.00	
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,509,400.00		466,509,400.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,980,234.64	-9,980,234.64	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		34,954,496.48	-34,954,496.48	
1 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15	15		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	12	12		100
8	Үйлчлэх ажилтан	2	2		100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Асгат сумын Хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,416,100.00	-23,416,100.00
21 УРСГАЛ ЗАРДАЛ	23,416,100.00	-23,416,100.00
210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,416,100.00	-23,416,100.00
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,416,100.00	-22,416,100.00
210301 Гэрэл, цахилгаан	1,421,491.19	-1,421,491.19
210302 Түлш, халаалт	20,482,308.81	-20,482,308.81
210303 Цэвэр, бохир ус	512,300.00	-512,300.00
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-1,000,000.00
210604 Урсгал засвар	1,000,000.00	-1,000,000.00
1 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,416,100.00	-23,416,100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Асгат сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

➤ СӨБ-ыг хүүхдүүдэд олгох

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн зорилго: Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Төрийн албаны тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
4. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
7. СӨБ-н тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Боловсролын ерөнхий хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Тендерийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын

ажил гүйлгээнд Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд:

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 705,870.7 мянган төгрөгөөр буюу 59.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	4.4	4.4
Бараа материал	18,674.4	21,741.4	3,067.0
Үндсэн хөрөнгө	132,067.1	147,954.9	15,887.8
Нийт хөрөнгө	160,721.8	204,655.3	43,933.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	155,796.1	186,174.4	30,378.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	160,721.8	204,655.3	43,933.5

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл байхгүй, тайлант онд 31,626.1 мянган төгрөгийн авлага барагдаж, 31,630.5 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 4.4 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 18,674.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 43,456.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 4,677.7 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 40,389.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 21,741.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,067.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдаж аваагүй, хөрөнгө оруулалтаар 28,411.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 9,215.3 мянган төгрөгийн

хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 194,855.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 12,523.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 489,925.5 мянган төгрөг, нийт зарлагыг 489,925.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 454,971.0 мянган төгрөг буюу 92.87 хувьтай байна. Энэ нь цалин, ажил олгогчоос төлөх ндш, хоол хүнс, бараа үйлчилгээний бусад зардал, зэрэг зардлыг 34,954.4 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80233	Хүүхэд хамгаалал	459.0	456.0	0	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	657.9	650.0	7.9	98.7%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	29,416.8	28,651.8	765.0	973%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,702.4	1,702.4		100%
81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	657.9	657.9	0	100%
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	1,252.4	1,252.4		0%
81834	Боловсролын стандарт сургалт	429,022.5	395,998.2	33,024.3	92.3
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	3,339.6	3,339.6		100%
	НИЙТ	466,507.5	432,708.3	33,799.2	92.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 22,416.1 мянган төгрөгийн санхүүжилт авч байна. Гүйцэтгэлээр 22,416.1 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, халаалт цэвэр ус, урсгал засварын зардалд тус тус зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 513,034.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,260,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,208,5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,350.0 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж, өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4: Зөвлөмжийн хэрэгжилт 100% биелүүлсэн

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2,350.0	1	2,350.0	100%
Нийт дүн	1	2,350.0	1	2,350.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, амархан муудаж, чанар байдал нь алдагдах хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж, удаан хугацаагаар хадгалахгүй байх, эд хариуцагчийн гаргаж байгаа бараа материалын тайланг сар бүр хянаж, үлдэгдлийг баталгаажуулж байх, Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн үед тооцоо бодож, үлдэгдлийг тулган баталгаажуулж байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,335.3 мянган төгрөгийн алдаа илэрч, 6,782.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

5.1 Төлбөрийн акт:

- **Илэрсэн алдаа:** Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал 6,782.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.
- **Шийдвэрлэсэн байдал:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5

- дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна", 2.5-д "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасныг тус тус зөрчсөнд 6,782.9 мянган төгрөгийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

- **Илэрсэн алдаа:** Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 552.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Шийдвэрлэсэн байдал:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Илэрсэн алдаа: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 61 төрлийн 8,943.3 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИГЭРСЭН БҮРҮҮ ИГЭРХИЙЛЛИЙН НЭЛТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэлтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Бүрүү тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруу-лаагүй	Тоо	Дүн
Дүн										

/Мянаг төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэлтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Харьццугаа тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагддаг ТҮБД-ийн эрхлэгч, багш туслах багшид эрхлэгчийн тушаалаар мөнгөн урамшуулал олгосон	1	6,782.9	1	6,782.9								
Хүүхдийн хоолны норм нормативыг мөрдөж ажиллах	1	552.4					1	552.4				
Анхны өртөө элэгдлээрээ нөхсөн О үлдэгдэлтэй байгаа 226 нэр төрлийн 1696 ширхэг 287,694,427.60 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах	1											
Дүн		7,335.3		6,782.9				552.4				

Үүнээс

/Мянаг төгрөгөөр/

